СЕХ-ны Тамгын газрын
2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн
3/06 албан бичгийн нэгдүгээр хавсралт

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ 2025 ОНЫ
“ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ”

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлалсан эсэх[4]		1	1	100
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	1	100
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0.5	0.50
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0.5	0.50
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5		
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5		
Хэсгийн оноо				**4**	**3**	50
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	100
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1	100
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	0	
Хэсгийн оноо				**3**	**2**	66
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	100
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	1	100
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	100
Хэсгийн оноо				**3**	**3**	100
Үнэлгээний нийт оноо, хувь				**10**	**8**	**80**

-oOo-

СЕХ-ны Тамгын газрын
2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн
3/06 албан бичгийн хоёрдугаар хавсралт

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"

НЭГ. Товч танилцуулга
Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын Ес зүйн дэд хороо нь Тамгын газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/48 дугаар тушаалаар байгуулагдсан. Ёс зүйн дэд хорооны даргаар Хуулийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Наранбат, нарийн бичгийн даргаар Захиргаа, удирдлагын газрын ахлах референт С.Баасанхүү, гишүүн Мэдээлэл, судалгаа, сургалтын төвийн ахлах референт Б.Нямсүрэн нарын бүрэлдэхүүнтэй. Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газар нь 35 албан хаагчтай.
ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт:
Байгууллагын хэмжээнд 1, 4 дүгээр улиралд Төрийн албан хаагчийн ёс зүйн төлөвшил, байгууллагын нээлттэй соёлыг хэвшүүлэх, дагалдуулах, чиглүүлэх сургалтыг зохион байгуулсан.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
Удирдах албан тушаалтны харилцааны соёл, ёс зүйгүй явдлыг халах, ёс зүйгээр манлайлах менежментийн арга барил, зорилго, зорилтуудаа тодорхой болгох ач холбогдол, удирдлагын шийдвэр, үүрэг даалгавар гаргах чадамжийг чанаржуулах тал дээр анхааран манлайлан ажилласан.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
Ёс зүй дэд хороо нь 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр баталж, хэрэгжилтийг ханган ажилласан.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
2025 онд Ёс зүйн зөрчил гомдлын талаар өргөдөл гараагүй, Ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлж, ёс зүйтэй ажиллах талаарх ойлголтыг 2 удаагийн сургалтаар олгосон.	Байхгүй. ***/2025 оны хувьд байгууллагын засвар, үйлчилгээтэй холбоотойгоор төлөвлөсөн ажлууд бүрэн хийгдээгүй/***
Санал:	

-Ёс зүйн дэд хорооны гишүүдийн мэдлэг, чадварыг чадавхжуулах сургалтыг үе шаттай зохион байгуулах

-Байгууллагын дотоод ёс зүйн сургалтад ашиглагдах бодит кейс, судалгааг авах.

Шалгах хэсэг:

- ☑ “Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт”-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☑ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☑ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан
Тамгын газрын дарга — Д.Бат-Эрдэнэ

Ёс зүйн дэд хорооны дарга

Хуулийн газрын дарга — Т.Наранбат

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
Захиргаа, удирдлагын газрын ахлах референт — С.Баасанхүү

2026.01.02

БАТЛАВ.
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА

Т.НАРАНБАТ
2025.01.02

9128719
УХА0306

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№		Үйл ажиллагаа	Хүрэх түвшин, үр дүн	Хугацаа	Хариуцах албан хаагч
Нэг. Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр					
1	1.1	Ёс зүйн хууль тогтоомжийг мөрдүүлж, ёс зүйтэй ажиллах талаар ойлголт, хандлага, соёлын өөрчлөлт бий болгох сургалтад нийт албан хаагчдыг хамруулах	Нийт албан хаагчдыг /44/ сургалтад хамруулсан байна.	I, IV дүгээр улирал	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
2	1.2	Төрийн албанд анх томилогдсон болон Тамгын газарт шинээр томилогдсон албан хаагчдад сургалт зохион байгуулах	Шинээр томилогдсон албан хаагчдад сургалт зохион байгуулагдсан байна.	Тухай бүр	Б.Нямсүрэн
3	1.3	Ёс зүйн хорооноос авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар нийт албан хаагчдад мэдээллийг тогтмол хүргэх	Албан хаагчийн тоо-44 Ёс зүйн зөрчлийн талаар мэдлэг ойлголтыг албан хаагчдад өгсөн байна.	Тухай бүр	Т.Наранбат
4	1.4	Ёс зүйн хэм хэмжээг эрхэмлэгч аян зохион байгуулах	Ёс зүйтэй албан хаагчийг шалгаруулсан байна.	Тухай бүр	Т.Наранбат
5	1.5	Ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг судалж, нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлон, зөрчлийг бууруулах арга хэмжээ авах	Ёс зүйн зөрчил буурсан байна.	IV дүгээр улирал	Б.Нямсүрэн
6	1.6	“Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх	Хөтөлбөрийн холбогдох заалтыг хэрэгжүүлсэн байна.	Тухай бүр	Т.Наранбат
Хоёр. Ёс зүйн хэм хэмжээг сахиулах, зөрчлийг хянан шийдвэрлэх					
6	2.1	Төрийн албан хаагчдын ёс зүйн асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийж, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох	Дүн шинжилгээ хийж, ёс зүйн зөрчил буурсан байна.	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн

7	2.2	Ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэж, дүгнэлтийг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх	Ирсэн гомдлыг хянан үзэж, шийдвэр гаргаж, эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн байна.	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
	Гурав. Ёс зүйн дэд хорооны зохион байгуулалт, хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр				
9	3.1	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, хэрэгжүүлэх	Төлөвлөгөөг батлуулж, хугацаанд хэрэгжсэн байх.	I дүгээр улирал	Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн
10	3.2	Ёс зүйн дэд хорооны хэвлэмэл хуудсыг хэвлүүлэх,	Хэвлэмэл хуудсыг хэвлүүлсэн байх.	I дүгээр улирал	С.Баасанхүү
11	3.3	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг батлуулах	Шаардлагатай төсвийг батлуулсан байх.	IV дүгээр улирал	Т.Наранбат
12	3.4	Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадавхжуулах сургалт, арга хэмжээнд хамруулах	Төрийн албан хаагчдад зориулсан Ёс зүйн 1, 2 дугаар түвшингийн сургалтад хамрагдсан байх.	Тухай бүр	Т.Наранбат
	Дөрөв. Үйл ажиллагааг тайлагнах, мэдээлэх чиглэлээр				
13	4.1	Мэдээ, тайланг тухай бүр Ёс зүйн хороонд хүргүүлэх	Хууль, тогтоомжид заасны дагуу хугацаанд хүргэгдсэн байна.	Тухай бүр	С.Баасанхүү
14	4.2	Нийтийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд зөвлөлийн үйл ажиллагаанд холбогдох шийдвэр, тайлан, мэдээг тухай бүр Сонгуулийн ерөнхий хорооны цахим хуудасны “Ёс зүйн дэд хороо” цэсэд байршуулах	Мэдээллийг тухай бүр байршуулсан байна.	Тухай бүр	С.Баасанхүү
15	4.3	Дэд хорооны үйл ажиллагааны тайланг Ёс зүйн хороонд хүргүүлэх, баримт бичгийг архивд хүлээлгэн өгөх	Хадгаламжийн нэгж болгон архивд хүлээлгэн өгсөн байна.	I дүгээр улирал	С.Баасанхүү

ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО